

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

“Их өртөө” ХК-ийн үнэт цаасыг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” журмын 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Их өртөө” ХК-ийн 180740 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компани хэлбэрээ өөрчилж байгаатай холбогдуулан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Их өртөө” ХК /Д.Туул/-д үүрэг болгосугай.

3. Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэж тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ